

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

Сайншандын салхин парк төсөл

Улс орон:	Монгол улс
Төслийн дугаар:	47397
Бизнесийн салбар:	Цахилгаан, эрчим хүч
Мэдэгдлийн хэлбэр:	Хувийн
Хүрээлэн буй орчны ангилал:	А
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын товлогдсон өдөр:	
Төлөв байдал:	Анхан шатны хурлаар батлагдсан, Эцсийн хурлаар орохоор бэлтгэгдэж байгаа
Төслийн хураангуй баримт бичгийг нийтэд нээлттэй болгосон:	

Төслийн танилцуулга

ЕСБХБ нь Улаанбаатар хотоос зүүн урагш 460км-ийн зайд байрших 55 МВт-ын хүчин чадалтай Сайншанд Салхин Парк (цаашид “Төсөл” гэх) салхин цахилгаан станцын бүтээн байгуулалт, барилга угсралт болон ашиглалтын ажлыг санхүүжүүлэхэд Сайншанд Салхин Парк ХХК-д (цаашид “Компани” гэх) 30 хүртэлх сая америк долларын тэргүүн ээлжинд эргэн төлөгдөх зээл (senior loan)-ийг олгохоор судалж байна.

Төслийн зорилго

Сайншанд Салхин Парк нь ЕСБХБ-наас 2012, 2016 онд тус тус санхүүжүүлсэн Салхитын салхин Парк, мөн Цэцийн салхин Парк төслийн дараа Монгол улсад хэрэгжүүлж буй салхины эрчим хүчний гурав дахь төсөл юм. Уг төсөл нь Монгол улсын нүүрс хүчлийн хийн үйлдвэрлэлийг багасгаж, эрчим хүчний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахад хувь нэмэр оруулах болно. Мөн уг төсөл нь Монгол улсын эрчим хүчний салбар дахь хувийн хэвшлийн байр суурийг бататгаж, тус улсын сэргээгдэх эрчим хүчний зорилтуудыг хангахад чухал хувь нэмэр оруулна.

Шилжилтийн нөлөөлөл

Төсөл нь дараах байдлаар шилжилтийн үйл явцад нөлөөлнө. Үүнд:

(i) Төсөл хэрэгжих хугацаанд Монгол улсын хүлэмжийн хий (CO₂) ялгаруулалтыг 5 сая хүртэлх хэмжээгээр бууруулж, нүүрсээр галладаг эрчим хүчний эх үүсвэр давамгайлсан салбарыг төрөлжүүлэхэд туслана.

(ii) Төрийн өмч давамгайлсан Монголын эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн шинэ оролцогчийг бий болгоход төслийн үр дүн оршино; Уг төсөл нь тус Банкны Ногоон Эдийн Засагт Шилжих (GET- Green Economy Transition) бодлоготой нийцэж байгаа болно.

Үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл

ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд Салхин Парк ХХК

Тус Компани нь Энжи, IFU (Дани улсын хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулах сан), Ферростаал Индустириал Прожектс зэрэг байгууллагууд дотоодын түнш компанитай хамтран эзэмших Монгол улсад бүртгэгдсэн тусгай зорилго бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

30,000,000.00 ам. доллар

30 сая ам. доллар хүртэлх (28.4 сая Евротоой тэнцэх) тэргүүн ээлжинд эргэн төлөгдөх эрхтэй зээлийг (senior secured loan) тус Компанид хязгаарлагдмал баталгаатай (limited recourse) төслийн санхүүжилтийн хэлбэрээр олгоно.

Төслийн нийт өртөг

120,000,000.00 ам.доллар

Байгаль орчин, нийгмийн талаарх тойм

Б ангилал (2014). Банкны Байгаль орчин, нийгмийн харилцааны нарийвчилсан үнэлгээ (ESDD) болон байгаль орчин, нийгмийн харилцааны хараат бус зөвлөх (IESC)-өөр хийлгэсэн үнэлгээгээр тус Төсөл нь Монгол улсын хууль дүрэм, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлага, Европын Хөрөнгө Оруулалтын Банк (EIB)-ны Байгаль орчин, нийгмийн харилцааны стандарт, эрсдэлийн үнэлгээ, удирдлагын стандарт болон Европын Холбооны байгаль орчны холбогдох стандартуудтай нийцэж байгаа нь баталгаажсан болно.

Байгаль орчин, нийгмийн харилцааны нарийвчилсан үнэлгээ (ESDD)-ний ажлын хүрээнд байгаль орчин, нийгмийн харилцааны хараат бус зөвлөхийг (IESC) төслийн газар дээр ажиллуулж, төслийн салхин станц болон түүний дамжуулах шугам, ашиглах автозамын Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIA), Техникийн бус тойм (NTS), Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (SEP), Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө (RAP) зэргийг хянасан болно.

Эдгээр баримт бичгийг Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө (ESAP) болон Газрын эзэмшилийг шилжүүлэн авах мэдээллийн хуудсын хамт Компаний вэбсайт (www.sainshandwindpark.mn) дээр Англи, Монгол хэлээр байршуулж нийтэд ил болгосон билээ.

Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө (RAP) нь одоогоор зөвхөн Англи хэл дээрх хувилбараар байршсан ба Төслийн хураангуй баримт бичгийг нийтэд нээлттэй болгосноос хойш хоёр долоо хоногийн дотор Монгол хэлэнд хөрвүүлж байршуулна.

Нийт 25 салхин трубин генератораас (WTGs) бүрдэх энэхүү 55МВт-ын төсөл нь Нийслэл Улаанбаатар хотоос зүүн урагш ойролцоогоор 460км зайд, Монгол улсын говийн бүс нутагт байрлах Сайншанд хотоос зүүн урагш 7км-ийн зайд хэрэгжинэ.

Уг төсөл нь Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Алтанширээ гэсэн гурван сумын газар нутгийн огтлолцол дээр хэрэгжинэ. Төслийн зориулалттай газар нь төрийн эзэмшилд байдаг бөгөөд уг газрыг Сайншанд Салхин Парк ХХК (Төслийн компани) нь 30 жилийн хугацаатайгаар түрээслэн авсан болно.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (EIA) болон бусад холбогдох баримт бичигт дурдсан асуудлуудын дотор агаар (тоос шороо, чимээ шуугиан, г.м.), ус, хаягдлын менежмент, тээврийн хөдөлгөөний менежмент, орчин тойрны үзэмжид (салхин турбин, сэнсний эргэлтийн сүүдэр) үзүүлэх нөлөөлөл, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, гэрээт байгууллагуудын менежмент, биологийн төрөл зүйл, соёлын өв, нутгийн малчдад учирч болох хязгаарлагдмал, түр зуурын эдийн засгийн хохирол (барилга угсралтын үеэр бэлчээрийн талбайгаа алдах г.м.) болон иргэдийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай 500м-ийн аюултай бүс дотор байрласан хоёр малчин айлын өвөлжөөг бүрмөсөн нүүлгэн шилжүүлэх зэрэг орж байна.

Төсөл хэрэгжих газрын ойролцоо Тусгай Хамгаалалтын Газар (SPAs) байхгүй хэдий ч, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн 6-р Шаардлагын дагуу төсөл нь байгалийн нэн чухал түшиц газрууд болон хамгаалах шаардлагатай чухал ургамал, амьтны төрөл зүйлд их хэмжээний сөрөг нөлөө үзүүлэхгүй болохыг баталгаажуулж ургамал, амьтны судалгааг нэмэлтээр хийсэн болно.

Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ (EIA) хийх , зөвшөөрөл авах үйл явцын үеэр хийсэн зөвлөх үйл ажиллагаа, мэдээлэлтэй хослуулж Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (SEP)-г боловсруулан гаргасан. Энэхүү төлөвлөгөө нь оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг илүү нарийвчлан гаргах, бүлэг тус бүрийн оролцоог хангах арга замуудыг тодорхойлох, мөн гарсан гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх албан ёсны бүтэцтэй болох, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, тайлагнахад шаардлагатай нөөц бололцоогоор хангах зэрэг зориулалттай.

Талуудын оролцоотой холбоотой үйл ажиллагааны хүрээнд 2015 онд улсаас хийсэн Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ (EIA)-ний явцын үр дүнг танилцуулах зорилгоор Сайншанд, Өргөн, Алтанширээ сумуудын олон нийттэй уулзалт зохион байгуулсан. Талуудын Оролцоог Хангах Төлөвлөгөөний дагуу төслийн барилга угсралтын үйл ажиллагааны өмнө болон явцын үеэр олон нийттэй дахин уулзалдаж зөвлөлдөх болно.

EIA үнэлгээнд төлөвлөсөн Төслийн сөрөг нөлөөг саармагжуулах арга хэмжээнүүдийг үр дүнтэй удирдаж хэрэгжүүлэхийн тулд Байгаль орчин, нийгмийн харилцааны менежментийн төлөвлөгөөнүүд (ESMPs)-ийг боловсруулж гаргасан.

ESMP нь Төслийн барилга угсралтын үед Инженеринг, худалдан авалт, барилгын ажил (EPC) хариуцсан гэрээт байгууллага, ашиглалтын үед талбай хариуцсан оператор байгууллагын боловсруулан хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн систем (EMS)-үүдийн суурь болох юм.

Төслийн байгаль орчин, нийгмийн үүрэг хариуцлагын хэрэгжилтийг хангах зорилгоор байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал хариуцсан мэргэшсэн ажилтан, мөн олон нийтийн харилцаа хариуцсан ажилтан зэрэг ажлын байрыг бий болгоно.

Банкны Гүйцэтгэлийн шаардлагуудад нийцүүлэх зорилгоор Байгаль орчин, нийгмийн харилцааны үйл ажиллагааны төлөвлөгөө (ESAP)-г Компанитай тохиролцсон. Уг

төлөвлөгөөнд (i) Төслийн Байгаль Орчин, Нийгмийн Харилцааны Системийг боловсруулж хэрэгжүүлэх, (ii) ОУСК/ЕСБХБ-ны удирамжийн дагуу Ажилчдын Байрны Менежментийн Төлөвлөгөөг бэлдэх, (iii) барилга угсралтын дараа бэлчээрийн газар нутгийн төлөвийг хянан шалгаж, бэлчээрийн зориулалтаар үргэлжлүүлэн ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох мөн бэлчээрийг зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нөхцөлд амьжиргааг нөхөн сэргээхэд шаардагдах арга хэмжээг төлөвлөх, (iv) ажилчдад (үүнд гэрээт ажилчид мөн орно) урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдалд хариу арга хэмжээ (Chance find procedure) авах буюу археологийн болон соёлын өвийг хамгаалах журмыг хэрэгжүүлэх талаар сургалт хийх

Эцэст нь тэмдэглэхэд, Банкны мэргэжилтнүүд, томилогдсон зөвлөхүүд Компани болон түүний үйл ажиллагааг тогтмол хянаж ажиллах болно.

Техникийн хамтын ажиллагаа

Төслийн энэ шатанд техникийн хамтын ажиллагаа явуулах төлөвлөгөө байхгүй байна.

Төслийн талаар холбогдох мэдээллийг:

Mr Holger Boy (Холгер Бой)

holger.boy@ferrostaal.com

Утас: 0049 201 818 2860

www.sainshandwindpark.mn

Hohenzollernstr. 24, 45128 Essen, Germany (Хохонцоллерн гудамж. 24, 45128 Эссен, Герман улс)

Бизнесийн боломжийн талаар:

Бизнесийн боломж, худалдан авалтын асуудлаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

Ерөнхий асуудлаар

ЕСБХБ-ны төсөлтэй холбогдолтой боловч худалдан авалттай холбоогүй асуудлаар хандах хаяг:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО (PIP)

Олон нийтийн мэдээллийн бодлого (PIP) нь ЕСБХБ-ны стратеги, бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, ойлголтыг илүү сайн түгээх зорилгоор мэдээллийг хэрхэн ил тод болгох, холбогдох талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах зарчмыг тодорхойлдог.

[Олон нийтийн мэдээллийн бодлогын бүрэн эх хувь](#)

ТӨСЛИЙН САНАЛ ГОМДЛЫН МЕХАНИЗМ (PCM)

ЕСБХБ нь Банкны санхүүжилттэй төслийн зүгээс ямар нэг хохирол учруулсан, учруулах магадлалтай гэх асуудлаар нэг буюу хэсэг хувь хүн, эсвэл аль нэг байгууллагаас гаргаж болох гомдлыг хараат бусаар хянан шийдвэрлэх үүднээс Төслийн санал гомдлын механизм (PCM) –ыг бий болгосон болно.

[Төслийн санал гомдлын механизмын Үйл ажиллагааны Дүрэм](#) | [Орос хэл дээрх хувилбар](#)

Төслийн санал гомдлын РСМ механизмын хүрээнд гаргах аливаа санал гомдлыг ЕСБХБ-ны сүүлийн санхүүжилт тараагдсанаас 12 сарын дотор гаргах ёстой. Та тухайн асуудлаар санал гомдол гаргах эрхтэй хугацааг сайн мэдэхгүй байгаа бол РСМ хариуцсан ажилтантай (rcm@ebrd.com) холбогдож тусламж авна уу.